



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

┌ Сургалт зохион байгуулах тухай ┐

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.7.6, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Налайх дүүргийн зургаадугаар хорооны иргэдийн дунд "Аж ахуй эрхлэх ур чадвар" сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 550,000 /таван зуун тавин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.


3. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2015 оны 06 сарын 30-ний өдрийн А/6-тоот
тушаалын нэгдүгээр хавсралт



**“АЖ АХУЙ ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ”
СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: Нийслэлийн Налайх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын орчны бүсийг нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн аялал жуулчлалын жишиг суурин болгон хөгжүүлэх зорилт, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд тус бүс нутгийн иргэдэд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх мэдлэг олгоход сургалтын зорилго оршино.

Сургалтын хөтөлбөр: Бизнесээ хөгжүүл

№	Хичээлийн сэдэв	Цаг	Заах багш
1	Бизнесийн шинэ санаа бизнесээ эхлэх, Бизнесээ хөгжүүлэх арга, зам	40 минут	“Бизнес эхэл, Бизнесээ хөгжүүл хөтөлбөр”-ийн сургагч багш нар Б.Нэргүй Я.Балгансүрэн
2	Маркетинг, бараа материал худалдан авах	40 цаг минут	
3	Бараа материалын нөөцийн хяналт	40цаг минут	
4	Өөрийн өртгийн калькуляц	40 цаг минут	
5	Санхүүгийн бүртгэл	40цаг минут	
6	Төлөвлөлт	40 цаг минут	
	Бүгд	4цаг	

Хамрах хүрээ: Налайх дүүргийн 6-р хорооны иргэд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид хамрагдана.

Сургалтын үр дүн: Аялал жуулчлалын гол бүс Горхи-Тэрэлжид үйл ажиллагаа явуулдаг жуулчны бааз, амралтын газрууд тэдгээрийн үйлчлүүлэгчид, аялагч, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг хорооны иргэд үйлдвэрлэж, нийлүүлэх боломж бүрдэнэ. Аялал жуулчлалын салбарыг дэмжсэн жижиг дунд үйлдвэрлэл өссөнөөр бүс нутгийн иргэдэд хүрэх эдийн засгийн өгөөж нэмэгдэнэ. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн хоорондын уялдаа холбоо сайжирч, бүс нутгийн хөгжилд сайнаар нөлөөлнө.


Зохион байгуулагч: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Налайх дүүргийн ЗДТГ, Налайх дүүргийн 6-р хороо

Хугацаа: 2015 оны 07-р сарын 03- ны өдөр 10.00-16.00 цаг

Болох газар: Нийслэлийн Налайх дүүргийн 6-р хорооны хурлын танхимд

Бүртгэх газар: Налайх дүүргийн 6-р хорооны байранд болно.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2015 оны 06 сарын 30 ний өдрийн 462 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



“АЖ АХУЙ ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ ЭЗЭМШҮҮЛЭХ”
СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Багшийн төлбөр /Би Жи сервис Б.Нэргүй/	4 цаг	100,000	400,000
2	Сургалтын цай, кофены зардал	40	3750	150,000
	Нийт дүн			550,000